

ХКН-ЫН ХҮИ ИХ ХУРЛЫН ТУХАЙ

Ц. БАТБАЯР*

2007 оны 10 дугаар сард хуралдсан ХКН-ын ХҮИ их хурлаар Хятадын хөгжлийн шинэ үзэл баримтлалыг албан ёсоор зарлан тунхаглав. Хөгжлийн асуудлыг зөвхөн эдийн засгийн өсөлт, тухайлбал Дотоодын Нийт Бүтээгдэхүүний /ДНБ/ өсөлтөөр тодорхойлж байсан өмнөх 30 жилийн практикаас татгалзаж, хөгжлийг иж бүрнээр эдийн засаг, нийгэм, байгаль орчин, хүний хөгжил зэрэг бүх талыг хамарсан нийгмийн процесс гэж үзэх болов. Хөгжлийн асуудлыг цоо шинээр авч үзэх болсныг зөвхөн онолын болон үзэл суртлын шинэчлэлт гэж үзвэл өрөөсгөл болно. Харин ХКН-ын шинэ удирдлагын зүгээс өмнөх 30 орчим жилийн эдийн засгийн өсөлтийн үр дүнд нийгэмд хуримтлагдсан зөрчилтэй асуудлуудад шүүмжлэлтэй бодитой хандаж тэдгээрийг засан залруулах, цаашдын хөгжлийг зөв удирдан жолоодох, нийгмийн зөрчлийг системийн хямрал болохоос урьдчилан сэргийлэх идэвхтэй эрэл хайгуул хийсний үр дүн бололтой.

ХКН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Ху Жинтао “Хятадын онцлогтой социализмын тугийг өндөрт өргөж, дунд зэргийн чинээлэг нийгэм байгуулж дуусгах үйл хэрэгт шинэ ялалт олохын төлөө тэмцье” сэдэвт илтгэл тавив. Тэрээр илтгэлдээ өнгөрсөн 5 жилийн хугацаанд хийсэн ажлын ололт амжилтаа дараах байдлаар дүгнэжээ. Үүнд:

- эдийн засгийн чадавхи үлэмж өссөн;
- өөрчлөлт, ил тод байдлыг дэлгэрүүлэх хүрээнд асар их амжилт олсон;
- ард түмний аж амьдрал мэдэгдэхүйц сайжирсан;
- ардчиллын байгуулалт, нийгмийн хэв журмыг хангах хүрээнд шинэ ахиц гарсан;
- соёлын салбарын бүтээн байгуулалтад

шинэ нөхцөл байдал бүрдсэн;

- нийгмийн байгуулалтыг бүрэн дүүрэн өрнүүлсэн;
- батлан хамгаалах хийгээд цэргийн салбарын бүтээн байгуулалтад түүхэн амжилт олсон;
- Сянган, Аомэнийн ЗЗТБ-ийн үйл ажиллагаа болон Тайваньтай харилцах ажил үлэмж сайжирсан;
- дипломат үйл ажиллагаанд асар их ахиц олсон;
- намын байгуулалтын ажил амжилттай урагшилсан.

Гэхдээ дээрх ололт амжилтад хүрэхийн тулд байгалийн баялгийг хэт их хайр найргүй ашигласан, хүрээлэн буй орчинг үлэмж бохирдуулсан зэргийг дурдаж хот, хөдөөгийн болон бүс нутаг хоорондын хөгжлийн зөрүү багасаагүй, хөдөө аж ахуйг тогтвортой хөгжүүлэх, тариачдын орлогыг нэмэгдүүлэх асуудал бэрхшээлтэй хэвээр, ажлын байр, нийгмийн хамгаалал, орлогын хуваарилалт, боловсрол, эрүүл мэнд, орон сууцны хангамж, эрх зүй, нийгмийн хэв журам зэрэг ард иргэдийн язгуур эрх ашигтай холбоотой олон салбарт хүндрэл, бэрхшээл их байгаа зэрэгт шүүмжлэлтэй ханджээ. Мөн намын үзэл суртал болон ёс суртахууны ажлыг улам сайжруулах, түүний удирдан чиглүүлэх үүргийг шинэ шаардлага, шинэ нөхцөл байдалд нийцүүлэх, намын анхан шатны байгууллагуудын ажлын хэт үлбэгэр, назгай байдлыг өөрчлөхөд онцгой анхаарч ажиллах болно гэж илтгэлд тэмдэглэжээ.

ХКН-ын их хурлаар ирэх 5 жилд баримтлах гадаад бодлогын стратегийн чиглэлүүдийг тодорхойлж өгөв. Үүнд “Хятад улс энх тайванч хөгжлийн замаар тууштай замнана. Энэ нь цаг үеийн хөгжлийн чиг хандлага болон өөрийн улсын язгуур эрх

* Ц.Батбаяр. Түүхийн ухааны доктор (Sc.D)

ашигт үндэслэн Хятадын засгийн газар, ард түмний хийсэн стратегийн сонголт юм. Бид Хятадын ард түмний эрх ашгийг бусад улс орнуудын ард иргэдийн нийтлэг эрх ашигтай уялдуулах эрмэлзэл төгс байгаа бөгөөд шударга ёс, тэгш эрхийн төлөө тууштай байна. ...Бүх улс орнуудын ард иргэд өөрсдийн хөгжлийн замаа сонгох эрхийг хүндэтгэх бөгөөд хэзээ ч бусад орны дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй, өөрсдийн хүслийг хүчээр тулгахгүй. Бид олон улсын маргаан, халуун цэгүүдийн асуудлыг энх тайвны аргаар шийдвэрлэхийн төлөө ажиллах бөгөөд олон улс, бүс нутгийн аюулгүй байдлын хамтын ажиллагааг хөгжүүлж, бүх хэлбэрийн терроризмийн эсрэг байна. Хятад улс өөрийгөө хамгаалахад чиглэсэн үндэсний батлан хамгаалах бодлого хэрэгжүүлнэ, зэвсэглэлээр хөөцөлдөхгүй, бусад аливаа улсад цэргийн занал учруулахгүй. Хятад улс бүх хэлбэрийн жанжлах үзэл, хүчний бодлогын эсрэг байна, эзлэн түрэмгийлэх үйл ажиллагаа хэзээ ч явуулахгүй” гэж тунхаглав.

Түүнчлэн Хятад улс өөрийн улсаа хөгжүүлэх замаар бүс нутаг, дэлхийн хөгжилд хувь нэмрээ оруулна. Өөрийн хөгжлийг урагшлуулахдаа бусад орнууд, ялангуяа хөгжиж буй орнуудын хууль ёсны эрх ашгийг харгалзан үзнэ. Олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн эдийн засаг, худалдааны дүрэм журмын дагуу зах зээлдээ нэвтрэх боломжийг нэмэгдүүлж, түншүүдийнхээ хуулийн дагуух эрх, эрх ашгийг хамгаална. Умард-Өмнөдийн ялгааг багасгахын тулд хөгжиж буй орнуудын бие даан хөгжих, ард иргэдийнхээ амьдралын түвшинг дээшлүүлэхэд туслах олон улсын хүчин чармайлтыг дэмжинэ гэдгээ батлав.

Хятад улс энх тайвнаар зэрэгцэн орших таван зарчмын үндсэн дээр бусад улс оронтой найрамдал, харилцаагаа хөгжүүлэх эрмэлзэл төгс байна. Хөгжингүй орнуудтай стратегийн яриа хэлцээ, харилцан итгэлцлээ гүнзгийрүүлж, хамтын ажиллагаагаа өргөжүүлнэ. Хоёр талын урт хугацааны тогтвортой харилцааг хөгжүүлэхийн тулд хоорондын зөрүүг зохистой байдлаар шийдвэрлэнэ. Хөрш орнуудын хувьд бид найрамдал, түншлэлийн харилцааны бодлогоо үргэлжүүлж, сайн хөршийн харилцаа, бодит хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлнэ. Бүс

нутгийн аюулгүй, тогтвортой орчныг хамтран байгуулахын төлөө бүс нутгийн хамтын ажиллагааг эрчимтэй хөгжүүлнэ. Хөгжиж буй орнуудтай эв санаа, хамтын ажиллагаагаа бэхжүүлэн, уламжлалт найрамдлаа гүнзгийрүүлнэ. Өөрийн бололцооны хэрээр хөгжиж буй орнуудад тусламж, дэмжлэг үзүүлж, хөгжиж буй орнуудын нийтлэг эрх ашиг, хууль ёсны шаардлагыг хангахын төлөө ажиллана. Бид олон улсын үйл хэрэгт идэвхтэй оролцоно, өөрийн олон улсын үүргээ биелүүлнэ, бүтээлч хувь нэмэр оруулна, олон улсын дэг журмыг илүү шударга, эрх тэгш болгохын төлөө ажиллана гэжээ.

“Хятад улс дэлхийгээс тусгаарлагдан ганцаар хөгжиж чадахгүй, дэлхий дахин ч Хятадгүйгээр хөгжил цэцэглэлт, тогтвортой байдалд хүрэх боломжгүй юм. Хүн төрөлхтөний сайн сайхан ирээдүйн төлөө хятадын ард түмэн цаашид ч бусад улс орны ард иргэдтэй хамтран ажиллах болно” хэмээн ХКН зарлан тунхагласан нь дэлхий дахины анхаарлыг татлаа.

Ойрын 5 жилд Хятад улсын дотоод, гадаад бодлогын зорилт, зарчим, тэргүүлэх чиглэлд эрс өөрчлөлт гарахгүй гэсэн дүр зураг харагдаж байна. Тус улсын гадаад бодлогын үндсэн зорилт урьдын адил өөрийн эдийн засаг, нийгмийн хөгжилд гадаад таатай орчин бүрдүүлэх, өөрийн олон улсын тавцан дахь байр суурийг улам бүр бэхжүүлэх, хэтдээ олон туйлт дэлхийн дэг журам байгуулах явдал байна. Гадаад бодлогын үндсэн чиглэлүүд нь хөгжингүй орнууд, хөрш зэргэлдээ орнууд, хөгжиж буй орнуудтай хамтын ажиллагаа хөгжүүлэх, олон талт хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох явдал байх бөгөөд бүс нутгийн хамтын ажиллагааг үндсэн чиглэлийн нэг болгож, хөгжиж буй орнуудтай харилцах харилцаанаас илүү ач холбогдол өгөх болсон нь онцлог байна. ХКН-ын ХҮИ их хурал өмнөх их хурлуудтай харьцуулахад гадаад харилцааны чиглэлээр дараах зарим онцлог санааг дэвшүүлэв. Үүнд:

1. Дотооддоо “эв зохицтой нийгэм” (harmonious society) байгуулах зорилт дэвшүүлж ажиллаж буйтай уялдуулж сүүлийн үед олонтаа яригдах болсон “эв зохицтой дэлхий” (harmonious world) байгуулах гэсэн санааг гадаад бодлогынхоо ерөнхий чиг

баримжаа болгохоо албан ёсоор зарлалаа. Үүнтэй холбоотойгоор илтгэлд өөрийн эрх ашгийг бусад улс орны эрх ашигтай уялдуулна, өөрийн хөгжлийг урагшлуулахдаа бусад орнууд, ялангуяа хөгжиж буй орнуудын хууль ёсны эрх ашгийг харгалзан үзнэ, бусад орнуудын үнээр ашиг олохгүй зэрэг санаа тусгагдсан байна.

2. Тус улсын хүчин чадал, нөлөө улс төр, эдийн засаг, цэрэг арми, соёл зэрэг бүхий л чиглэлд эрчимтэй нэмэгдэж байгаатай уялдуулан “Хятадын аюул” гэсэн ойлголт тархах болсныг намжаах зорилгоор гаргаж ирсэн “энх тайвнаар хөгжих” санааг мөн албан ёсоор зарлаж, гадаад бодлогынхоо ерөнхий зарчим болголоо. Уг санааг анхлан дэвшүүлж байхад “энх тайвнаар сэргэн мандах” гэсэн хэллэгийг ашиглаж байсан боловч энэ удаагийн хуралд “энх тайвнаар хөгжих” гэсэн хэллэгийг хэрэглэснээр энэ хоёр хэллэгийн аль нь оновчтой эсэх талаар дотооддоо нэгдсэн ойлголтод хүрсэн нь харагдаж байна.

3. Тайваний талаар нэлээн хатуу байр суурь илэрхийлэх байх гэсэн таамаглал байсан боловч Ху Жинтао дарга илтгэлдээ аядуу хандлага илэрхийлж, хоёр эргийн дайсагналыг албан ёсоор зогсоох, энх тайвны гэрээ байгуулах, хоёр эргийн харилцааг энх тайвнаар хөгжүүлэх механизм бий болгож энх тайванч хөгжлийн шинэ үе шатанд орохыг уриалсан нь “эв зохицтой нийгэм” байгуулах, “энх тайвнаар хөгжих” бодлоготой нь холбоотой, эдгээр бодлогоо бодитойгоор хэрэгжүүлэх эрмэлзэлтэйгээ нотлохыг хүссэнтэй нь уялдаатай байж болох юм.

2007 оны 10 дугаар сард болсон ХКН-ын ХҮИ их хурлаар нийгмийн тэнцвэртэй хөгжлийг хангах үүднээс “эв тэгш буюу эв зохицтой социалист нийгэм” бүтээн байгуулах тухай зорилтыг дэвшүүлэв. Нийгмийн шударга ёс болон хүн амын амьдралын тэгш байдлыг хангах, тэгснээр “нэг хэсэг нь түрүүлж чинээлэгжих” онолоос “нийтээр чинээлэгжих” онолд шилжих тухай Хятадын цаашдын хөгжлийн стратеги, тактикт зарчмын чанартай өөрчлөлт гарч байна.

ХКН-ны ТХ-ны тайлан илтгэлд дурьдсанаар Хятадын ДНБ-ий нэг хүнд ногдох хэмжээг 2020 он гэхэд 2000 оныхоос 4 дахин нэмэгдүүлэх том зорилт дэвшүүлэв.

Хятадын Үндэсний статистикийн Ерөнхий газрын орлогч дарга Сюй Суаньчунь энэ талаар: “ДНБ-ий нийт хэмжээг 4 дахин нэмэгдүүлэхээс нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээг 4 дахин нэмэгдүүлнэ гэдэг нь хүн амын өсөлтийн хүчин зүйлийг бодолцож үзсэн ч маш өндөр үзүүлэлттэй дундаж чинээлэг нийгэм /сяокан шэхуй/ байгуулах тухай ойлголт юм. Нөгөө талаар, түүхий эдийн орцын зардлыг багасгаж, байгаль орчныг хамгаалах шаардлага давхар тавигдах болсон нь хариуцлагыг өндөржүүлж байна. Энэ нь дараагийн 5 жилд иргэдийн амьдралд маш их өөрчлөлтийг авчрах ёстой бөгөөд маш тод мэдрэгдэх ёстой” гэж мэдэгджээ. 2000 онд нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 7078 юань байв. ХКН-ийн их хурлаас тавьсан зорилтын дагуу 2020 онд энэ хэмжээ одоогийн ханшаар 26000 юань болох нь байна.

ХКН-ын ХҮИ их хурал хөгжлийн шинэ үзэл баримтлалыг дэвшүүлж, зарим шинэ томъёоллыг намын дүрэм, мөрийн хөтөлбөрт тусгаж өгөв. Үүнд:

Нэг: Хятадын онцлогтой социализм: “бүтээн байгуулалт”-аас “хөгжил” рүү: 17 дугаар их хурлын илтгэлд шинэчлэлт, нээлттэй бодлогыг хэрэгжүүлсэн түүхэн үйл явцыг дүгнэхдээ “Шинэчлэлт, нээлттэй бодлого нь тухайн үед улсын хувь заяаг шийдвэрлэсэн чухал сонголт байсан. Энэ нь Хятадад өөрийн онцлог бүхий социализм байгуулахад чиглэсэн хятадын ард түмний аугаа их мандан бадралын зөв зам байсан”. ХКН-ын 13 дугаар их хурлаас хойш “Хятадын онцлогтой социализмыг бүтээн байгуулах” зорилт тавьж байсан бол 17 дугаар их хурлаас “Хятадын онцлогтой социализмыг хөгжүүлэх” зорилтыг тавьж байна.

Хоёр: Нэг их зам, 5 чиг шугам: **Илтгэлд:** “Хятадын онцлогтой социализмын замаар замнах” бодлого буюу нэг их замыг тодорхойлохын хамт 5 тодорхой чиг шугамыг зааж өглөө. Энэ нь Хятадын онцлогтой шинэчлэлт, Хятадын онцлогтой шинэ үйлдвэржүүлэлт, Хятадын онцлогтой ХАА-н шинэчлэлт, Хятадын онцлогтой хот сууринжуулалт, Хятадын онцлогтой улс төрийн хөгжлийн чиг шугам мөн гэжээ.

Гурав: “Нийт хэмжээ”-г “нэг хүнд ногдох хэмжээ” болгон 4 дахин нэмэгдүүлнэ: ХКН-ын 15,16 дугаар их хурлаас 21 дүгээр зууны эхний 10 жилд ДНБ-ны хэмжээг 2000 онтой харьцуулахад 2 дахин, 2020 он гэхэд 4 дахин тус тус нэмэгдүүлэхээр зорилт тавьж байсан. 16 дугаар их хурлаас хойшхи эдийн засгийн тасралтгүй, хурдтай хөгжлийн үр дүнд 2006 оны байдлаар энэхүү зорилт хэрэгжих бүрэн боломжтой нь нотлогдсон. Иймд энэ удаагийн их хурлаас “нийт хэмжээ”-г “нэг хүнд ногдох хэмжээ” болгон өөрчиллөө.

Дөрөв: “Экологийн соёл” –ын тухай анх удаа илтгэлд оруулав: “Экологийн соёлыг бий болгож байгалийн нөөц баялаг, эрчим хүч хэмнэх, хүрээлэн буй орчинг хамгаалсан үйлвэрлэлийн бүтэц, хэрэглээний арга хэлбэрийг бүрдүүлнэ” гэж заажээ. 12 дугаар их хурлаас 15 дугаар их хурал хүртлэх хугацаанд намаас социализмын материаллаг болон оюуны соёлыг чухалчилж иржээ. 16 дугаар их хурал өмнөх суурь дээрээ үндэслэн улс төрийн соёлыг дэвшүүлэн гаргаж тавьсан. Харин 17 дугаар их хурлаас экологийн соёлыг чухалчлах болсон нь намын зүгээс шинжлэх ухаанч хөгжил, эв зохицтой хөгжлийн тухай ойлголтыг гаргаж тавьсантай холбоотой гэж үзэж болно.